



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 6/52

Чингис хот

М.Урандолгионыг хөдөлмөрийн
гэрээгээр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 23.2, 23.2.2, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн 3.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа үйлчилгээ, хүнс, хөдөө, аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалд ажлын зайлшгүй шаардлагаар Мягмарбаатарын Урандолгионыг 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм цуцлагдах хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. М.Урандолгионы цалинг ТЗ-5-1 шатлалтай адилтган тогтоож, үндсэн цалинг 642,388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг М.Урандолгионд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030347